Эрүүл мэнд, спортын сайдын 2016
оны 02 сарын 23-ны 52 дугаар
тушаалын хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ **(МАЯГТ №3)**

## УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГТ

2022 оны 02 сарын 17-ны өдөр

| № | Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн заалт | Шалгуур үзүүлэл-тийн дугаар | Зөвлөмж | Хэрэгжүүлэх арга зам |
|---|---|---|---|---|
| БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД | | | | |
| Дэд бүлэг 1: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ | | | | |
| 1. | Байгууллага нь үзлэг, оношилгоо, эмчилгээ, ажилбар, үйлдэл хийхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таних үйл явцыг тодорхойлж баталгаажуулсан байх | 1.1 | Эмнэлгийн ерөнхий эмчийн баталсан үйлчлүүлэгчийг зөв таньж тусламж, үйлчилгээ үзүүлэх журамд мэс засал, мэс ажилбар, эмчилгээ хийх, эм өгөх, тариа хийх, тусгай хоол хүргэх ЦЦБ сэлбэх, ХБҮ-ийг зөв таних талаар тусгах хэрэгжүүлэх<br>Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Олон улсын зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах | - Үйлчлүүлэгчийг зөв таньж, тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг тодорхойлсон журмыг нийт ажилтнуудад танилцуулах, сургах, мөрдөх, хэрэгжилтэнд тогтмол дотоод хяналт тавих |
| 2. | Байгууллага нь үйлчлүүлэгчийг зөв таних аргыг тодорхойлсон хэрэглэдэг байх | 1.2 | | - Үйлчлүүлэгчийг зөв таних 2-оос доошгүй аргыг байгууллагын хэмжээнд баталгаажуулах, хэрэглэж хэвших. |
| 3. | Ямар нэг ажилбар, үйлдэхийн өмнө үйлчлүүлэгчийг таньдаг байх | 1.3 | Үйлчлүүлэгчийг таних аргыг тусламж үйлчилгээнд хэрэглэдэг байх, хэвших | - Үзлэг, оношлогоо эмчилгээний ажилбар /мэс засал, мэс ажилбар, эмчилгээ хийх, эм өгөх, тариа хийх, тусгай хоол хүргэх/ хийхийн өмнө үйлчлүүлэгчийг таних аргыг хэрэглэж хэвшүүлэх, хяналтын хуудас хөтлөх. |
| 4. | Тасаг, нэгжид өндөр эрсдэл үүсгэх, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн хэрэглээнд хяналт хийдэг байх | 5.4 | ЭМСС-ын 2015 оны 68-р тушаал "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, ханган нийлүүлэх журам батлах тухай",<br>Эмийн аюулгүй байдал, эрсдэлээс сэргийлэх, хяналт зохион байгуулах журам боловсруулах, мөрдөж ажиллах | - Өндөр эрсдэлт эмүүдийн ялган тусгаарлалт, аюулгүй хэрэглээнд хяналт санамж анхааруулга хийх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалт, хадгалалтанд хяналт үнэлгээ хийх. |
| Дэд бүлэг 4. ҮЗЛЭГ ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭ | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5. | Амбулаториор хийгдэх ажилбар, үйлдлийн жагсаалттай байх | 1.3 | Эмнэлгийн мэргэжилтний гардан үйлдэл гүйцэтгэх ур чадварт үнэлгээ хийдэг байх;<br>Гардан үйлдлийн хяналтыг дүгнэн сургалт, дадалжуулах ажлыг үе шаттай хийж хэвших; | - Эмнэлгийн мэргэжилтний гардан үйлдэл гүйцэтгэх ур чадварт үнэлгээ хийдэг байх;<br>- Гардан үйлдлийн хяналтыг дүгнэн сургалт, дадалжуулах ажлыг үе шаттай хийж хэвших; |
| 6. | Түргэн тусламжийн автомашинд тусламж үзүүлэхэд шаардлагатай багаж, эм,эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангасан байх | 3.3 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/294 тоот тушаалын 2 дугаар хавсралтыг хэрэгжүүлэн ажиллах; | - Түргэн тусламжийн автомашинд байх багаж, эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг баталсан байх;<br>- Жагсаалтын дагуу багаж, эм, эмнэлгийн хэрэгслийг бүрэн хангасан, нөхөн хангалтыг хийдэг байх;<br>- Бэлэн байдалд хяналт тавьж хэвших; |
| Дэд бүлэг 5. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ | | | | |
| 7. | Халдварын сэргийлэлт хяналт хариуцсан мэргэжилтэн ажиллуулдаг байх | 1.2 | ЭМС-ын 2019 оны 536 тоот тушаалын 1 дугаар хавсралтын хэрэгжилтийг хангаж ажиллах | - ЭМС-ын 2019 оны 536 дугаар тушаалын дагуу төв эмнэлэг нь халдварын сэргийлэлт хяналт (ХСХ)-ын асуудал хариуцсан орон тооны болон орон тооны бус албатай ажиллана.<br>- ХСХ-ын орон тооны албанд тархвар судлаач нараас гадна эмнэлзүйч эмч, сувилагчийг томилж ажиллуулах.<br>- Үндсэн орон тоогоор ХСХ-ын асуудал хариуцсан эмчийг томилох боломжгүй бол ХСХ-ын талаар мэдлэгтэй, сонирхолтой, бусдыг манлайлж ажиллах чадвартай эмчид нэмэлтээр хариуцуулж, ажлын цагийн менежментэд зохицуулалт хийх.<br>- ХСХ асуудал хариуцсан сувилагчийг орон тоогоор ажиллуулах.<br>- Тасаг нэгжүүд дэх ХСХ-ын орон тооны бус албаны үйл ажиллагааг сайжруулах<br>- Тархвар судлаач эмч нарыг мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамруулах |
| 8. | Эрүүл мэндийн ажилтан /ЭМА/-ы гарын эрүүл ахуй сахилтад хяналт, үнэлгээ хийсэн байх | 1.4 | ЭМА-ны гарын эрүүл ахуй сахилтын үнэлгээг сайжруулах | - ЭМА-ы гарын ариун цэвэр сахилтад тавьж байгаа хяналт нь гар угаах нөхцөл бүрдүүлсэн байдлаг, мэдлэг шалгах үнэлгээгээр хязгаарлагдаж байна. Цаашид:<br>- Гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын үнэлгээг ДЭМБ-ын аргачлалын дагуу жилд 1ээс |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | доошгүй удаа тусламж, үйлчилгээнд биечлэн оролцдог бүх ЭМА-ыг бүрэн хамруулж, хийж түвшинг тогтоох<br>- Спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэх бүтээгдэхүүний хэрэглээнд улиралд 1-ээс доошгүй удаа хяналт хийх. Тасаг нэгжээр үйлчлүүлсэн хүн амд харьцуулан дүгнэлт хийх |
| 9. | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тохиолдлыг илрүүлж, мэдээлдэг, халдварын эрсдлийг бууруулах арга хэмжээ авдаг байх | 5.2 | ЭМС-ын 2019 оны 539 дүгээр тушаалын дагуу ЭТҮХХ илрүүлэх тандалт, судалгааг сайжруулах | - Мэс засал, судасны гуурс, шээлгүүр, зохиомол амьсгалын аппаратад байгаа үйлчлүүлэгчдийн дунд халдвар илрүүлэх тандалтыг сайжруулах<br>- Дээрх тусламж үйлчилгээг авсан нийт үйчлүүлэгчээс хэд нь халдварт өртөж байгаа түвшинг сар тутам, ажилбар тус бүрээр гаргаж, дүн шинжилгээ хийж ажиллах. Мэс заслын шархны халдварын түвшинг мэс засал тус бүрээр гаргах.<br>- ЭТҮХХ-ыг чиглэлээр зорилтот тандалт, судалгаа хийх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, дэмжих, хөгжүүлэх |
| 10. | Хоол үйлдвэрлэлийн тасаг, хэсгийн барилга байгууламж стандартын шаардлага хангасан байх | 10.1 | Хоол үйлдвэрлэлийн байрны засвар, тохижилтыг сайжруулах | - Хоол үйлдвэрлэлийн байранд их засвар хийж тохижуулах, хүйтэн, цанатсан байгаа шалтгааныг тогтоон арилгах арга хэмжээ авч ажиллах<br>- Хана, тааз, шалыг угааж цэвэрлэхэд хялбар тэгш гадаргуутай болгох, агааржуулах хоолойд тортой хаалт хийх<br>- Бохирын шугам, хоолой, тосгуурыг засварлах<br>- Шавж устгалыг мэргэжлийн түвшинд хийлгэх, үүрлэсэн шавж, мэрэгчийг устгах ажлыг нэн даруй хийх |
| Дэд бүлэг 6. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 11. | Үйлчлүүлэгч эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл авах нөхцөлөөр хангагдсан байх | 3.3 | "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" "MNS6330:2017", стандартыг мөрдөх | - Хэвтэн эмчлүүлэгсдэд ЭМБО, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зөвлөгөө өгдөг байх. |
| БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД | | | | |
| Дэд бүлэг 1: ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12. | Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийгдэх хяналт, үнэлгээ хэвшсэн байх | 5.1 | Монгол улсын засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, дотоод хяналт хийх хяналтын хуудсыг чиглэл бүрээр боловсруулан хяналтыг тогтмол хийх. | - Дотоод дотоод хяналт, үнэлгээний багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан тушаалтай байх,<br>- Дотоод хяналт хийх чиглэл бүрээр /хяналтын хуудас боловсруулан, дотоод хяналт хийх графикын дагуу хяналтын хуудсаар хяналтыг тогтмол хийж, дүгнэж, хяналтын үр дүнг тооцох.<br>- Хийгдсэн хяналт, үнэлгээний тайлан, дүгнэлттэй байх,<br>- Гарсан зөвлөмж, түүний дагуу арга хэмжээ авсан байх,<br>- Хяналт, үнэлгээний дүгнэлтийг удирдлагын зөвлөлөөр хэлэцүүлдэг байх. |
| Дэд бүлэг 2: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН УДИРДЛАГА | | | | |
| 13. | Тасаг, нэгж бүрийн үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг байх. | 2.2 | Тусламж үйлчилгээний нэгж бүрт үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг байх. | - Тасаг, нэгжийн үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний төрөл бүрээр чанар, аюулгүй байдлын өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан батласан байх,<br>- Тусламж, үйлчилгээний төрөл бүрээр баталсан шалгуур үзүүлэлтийг тогтмол хэмжиж, дүн шинжилгээ хийдэг, дүгнэлт, тайлантай байх,<br>- Үр дүнг нийт ажилтнуудад танилцуулдаг байх,<br>- Үндэсний болон олон улсын түвшинд мөрддөг үзүүлэлтүүдтэй харьцуулж, сайжруулах арга хэмжээ авч ажилладаг байх. |
| Дэд бүлэг 3: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ | | | | |
| 14. | Ажилтан нэг бүрээр хувийн хэргийг бүрдүүлсэн, баяжилт хийгддэг байх. | 1.7 | Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Төрийн албан хаагыийн хувийн хэрэг хөтлөх журам"- нэгдүгээр хавсралт, "Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5095:2017 стандартын 6.10 дахь заалтыг хэрэгжүүлэх. | - Ажилтан нэг бүрээр хувийн хэргийг холбогдох стандарт, журамд заасны дагуу бүрдүүлсэн байх.<br>- Жил бүр баяжилт хийгдсэн байх. |
| Дэд бүлэг 5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЗАСВАР, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 15. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасаг, нэгжтэй байх | 1.1 | Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандарт, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн тоног төхөөрөмжийн тасаг, алба, нэгж /ажилтан/-ийг зохион байгуулж | - Нэгдсэн эмнэлийн стандартын шаардлагын дагуу тоног төхөөрөмжийн инжененр, техникч нарыг орон тоогоор ажиллуулах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ажиллуулах | |
| 16. | Ажлын байр нь эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын шаардлагыг хангасан байх | 1.4 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийдэг байх | - Инженер, техникийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа явуулах стандартын шаардлага хангасан өрөөтэй байх<br>- Механик засвар үйлчилгээ хийх зориулалтаар тоноглосон тусдаа өрөөтэй байх<br>- Засвар ба хяналт тохиргооны багажаар инженер бүрийг хангасан байх<br>- Электроникийн болон механик засварын багажаар хангах |
| 17. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтны мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авсан байх | 2.4 | Инженер, техникийн ажилтны мэргэшил, ур чадварыг тогтмол дээшлүүлдэг байх | - Өндөр өртөгтэй, нарийн бүтэц, ажиллагаатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн сургалтад заавал хамруулах, чадавхжуулах, мэргэшүүлэх, туршлага судлахад дэмжлэг үзүүлдэг<br>- Шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, нутагшуулах багийн үйл ажиллагаанд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийг оролцуулдаг<br>- Өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэхэд үе шаттай бодьтой дэмжлэг үзүүлэдэг байх |
| 18. | Тоног төхөөрөмж бүрийг газардуулгын системд холбож, аюулгүй ажиллагааг хангасан байх | 4.5 | Тоног төхөөрөмж бүрийн аюулгүй ажиллагааг хангах | - Мэргэжлийн байгууллагаар жилд 2-оос доошгүй (өвөл, зун) удаа цэг тус бүр дээр газардуулгын хэмжилт хийлгэж, дүгнэлт гаргуулсан<br>- Цахилгаан дамжуулах утасны бүрэн байдал, хүн хүрэлцэх (унтраалга, сэлгэн залгах автомат зэргийн битүүмжлэл) хэсгийн аюулгүй байдлыг хангах<br>- Тоног төхөөрөмжийг ажиллуулахдаа газардуудах байгууламжид холбож хэвших<br>- газардуулах байгууламжийн эсэргүүцэл зохих хэмжээндээ байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэн (хэзээ ч хэмжихэд 4 Ом-оос ихгүй эсэргүүцэлтэй байх техникийн нөхцлийг бүрдүүлэх) хяналт тавих<br>- Статик цэнэгт өртөхөөс урьдчлан сэргийлэх зохих арга хэмжээнүүдийг хэрэглэж хэвших |
| Дэд бүлэг 6. БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 19. | Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгэвэртэй байх | 2.1 | Цахилгааны нөөц үүсгэвэр нь байгууллагын хэмжээнд тусламж, үйлчилгээг хэвийн явуулах хүчин чадалтай байх | - Үндсэн цахилгаан тэжээл нль өөр хоорондоо хамааралгүй эх үүсвэр байхаас гадна ямар нэг байдлаар үндсэн цахилгаан тэжээл тасарсан тохиолдолд байгууллагыг хүчин чадалд тохирсон 3 дагч цахилгааны нөөц үүсгэвэртэй байж сэлгэн залгагдаж хэрэглэгчид хэвийн ажиллах нөхцлөөр хангах нөхцлийг бүрдүүлсэн байна.<br>- Олон бага хүчин чадалтай нөөц үүсгэвэр /дизль станц/-ууд шаардлагатай үед эмнэлгийн хэвийн үйл ажиллагаа хангах техникийн нөхцөл бүрдсэн эсэхэд хяналт тавьж ажиллах |
| 20. | Цахилгааны нөөц тэжээлийн найдваржилт хангагдсан байх | 2.2 | | - Тухайн байгууллагын АВР /Автомат сэлгэн залгагч/-ийн ажиллах техникийн болон схем зурагтай байх<br>- Нөөц тэжээлийн хүчин чадал нь тухайн байгууллагын /тасгийн/ тоног төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадлаас багагүй байх<br>- Нөөц тэжээлийн сэлгэн залгалтын шуурхай ажиллагаа, найдваржилтыг хангаж буйг мэргэжлийн байгууллага зохих туршилтаар баталгаажуулсан |
| 21. | Цахилгаан энергийн чанарын шаардлагад нийцсэн байх | 2.3 | Эмнэлгийн цахилгаан тэжээлийн чанарыг дээшлүүлэх | - Эмнэлгийн цахилгаан тэжээл нь MNS 1778:2007 стандартад нийцсэн эсэхийг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хэмжилт, туршилт хийлгэж цахилгаан тэжээлийн чанарыг дээшлүүлэх талаар арга х эмжээ авсан байх<br>- Хэмжилт хийх цэгүүдийг цахилгаан энергийн чанар доголдож болзошгүй /мэдрэмтгий/ хэрэглэгчид хийлгэдэг (ЭКГ, ЭХО, КТ...) байх<br>- Цахилгаан энергийн чанарыг доголдуулж болзошгүй /шугаман бус/ хэрэглэгчийн (рентген, UPS, физик эмчилгээний тоног төхөөрөмжүүд) оролт дээр хэмжилт, туршилт хийлгэж цахилгаан тэжээлийн чанарын шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлосон байх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 22. | Галын аюулгүй байдал, гал унтраах техник, хэрэгслийг ашиглах талаар ажилтнуудыг сургалтанд хамруулсан байх | 4.1 | Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах | - Байгууллагын хэмжээнд мөрддөг галын аюулгүй ажиллагааны батлагдсан заавартай, мөрддөг<br>- Харьяалах нутаг дэвсгэрийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран ажилтнуудад жилд 1-2 удаа галын аюулгүй байдлын дадлага, сургалтыг зохион байгуулж, баримтжуулсан<br>- Галын аюулаас урьдчилан сэргийлэх буланг шаардлагатай цэгүүдэд байршуулсан<br>- Гал унтраах хэрэгслийг ашиглах заавbooрыг өгдөг |
| 23. | Гал гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах тусгай тэмдэг бүхий гарц, схем зураглалтай байх | 4.2 | Галын аюулын үед ажиллах схем зураглал байрлуулах | - Аврах гарцын схемыг боловруулан зохих албан тушаалтангаар батлуулж, тэмдэг тэмдэглэгээнүүдийг шаардлагатай цэгүүдэд /хараны түвшинд/ байршуулах<br>- Гал унтраах бүлгэмтэй<br>- Галын гидрантын тоог эрс нэмэгдүүлж ажиллагаанд оруулах<br>- Гал унтраах хэрэгслээр хангасан, шаардлагатай цэгүүдэд байршуулсан |
| 24. | Галын хорыг шаардлагатай өрөө, нэгжид зохих журмын дагуу байрлуулж, хорыг цэнэглэсэн ба ашигласан бүртгэлийг хөтөлдөг байх | 4.5 | Галын хорыг нэмэгдүүлж, шаардлагатай цэгүүдэд байрлуулах | - Галын хорын тоог гаргаж, бүртгэлжүүлсэн<br>- Шаардлагатай цэгүүдэд галын хорыг байршуулсан<br>- Мэргэжлийн байгууллагатай гэрээтэй ажиллаж, цэнэглүүлсэн баримттай<br>- Галын хорыг цэнэглэсэн ба ашигласан бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн<br>- Техник ашиглалтын паспорт хөтөлсөн тэмдэглэлтэй<br>- Галын хорыг худалдан авсан, цэнэглэсэн санхүүгийн баримттай |
| БҮЛЭГ 3. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИ | | | | |
| Дэд бүлэг 1. АМЬ ТЭНССЭН ҮЕИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 25. | Тусламж, үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байх | 4.1 | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 30-ны А/814 тоот тушаалыг хэрэгжүүлэн ажиллах | - Яаралтай тусламжийн багаж, эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтын дагуу эмийн хангамжийн аюулгүй байдлыг хангах;<br>- Ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийг жагсаалтын дагуу хяаглалт хийх;<br>- Ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн хадгалалт хэрэглээнд хяналтын хуудсаар нарийвчилсан хяналт хийж, үр дүнг тооцох; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 26. | Тусламж үзүүлэхэд Шаардлагатай автомашины бэлэн байдлыг хангаж, дохиолол, дуудлагын системийг байрлуулсан байх | 4.5 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны 06 сарын 21-ны А/294 тоот тушаалыг хэрэгжүүлэн ажиллах | - Автомашины бэлэн байдалд хяналт хийн багаж тоног төхөөрөмжийг нөхөн сэлбэж байх;<br>- Автомашин болон багаж, тоног төхөөрөмжид цэвэрлэгээ, халдваргүйтгэл /ариутгал/ хийх заавартай түүнийг мөрдөж ажиллах; |
| Дэд бүлэг 2. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 27. | Үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг бүрэн ажиллуулсан, мэргэшсэн байх | 2.1 | "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" "MNS6330:2017", стандартыг мөрдөх | - Тусламж үйлчилгээний чиглэл, нэгж бүрээр сувилагч тусгай мэргэжилтний ажлын байрны зураглал хийсэн байх<br>- Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэлд хийсэн үнэлгээ хийдэг байх |
| 28. | Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг баталж, дүн шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээ авах | 3.2. | "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" "MNS6330:2017", заалтыг, MNS4621-2008 стандартыг мөрдөн ажиллах | - Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын өвөрмөц шалгуур үзүүлэлтийг гаргаж батлуулан мөрддөг байх<br>- Үр дүнг тооцон хяналт тавьдаг байх |
| 29. | Тусламж үйлчилгээ үзүүлэхэд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангадаг байх | 4.5 | "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" "MNS6330:2017", заалтыг , Эрүүл мэндийн сайдын 2019-12-12 ны А/566 тушаалын 1-р хавсралтыг хэрэгжүүлэн ажиллах | - Сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж ажиллах,<br>- Тусламж үйлчилгээг хянах хяналтын хуудас боловсруулж, хяналт хийн, үр дүнг тооцон ажиллах<br>- Сувилахуйн чиглэлээр сургалт, дадлагыг тогтмолжуулах /үйлчлүүлэгчийг таних/ |
| Дэд бүлэг 3. ЭМИЙН МЕНЕЖМЕНТ БА ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ | | | | |
| 30. | Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм /антикаогулянт, инсулин, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, хими эмчилгээний эм, тариа/-ийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлсэн байх | 3.7 | ЭМСС-ын 2015 оны 68-р тушаал "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, ханган нийлүүлэх журам батлах тухай" Эмийн аюулгүй байдал, эрсдэлээс сэргийлэх, хяналтын зохион байгуулах журам боловсруулах, мөрдөж ажиллах | - Өндөр эрсдэлт эмүүдийн ялган тусгаарлалт, аюулгүй хэрэглээний санамж анхааруулга хийх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зарцуулалт, хадгалалтанд хяналт тавьж ажиллах |
| 31. | Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хэрэгцээ, хэрэглээнд хяналт хийдэг байх | 3.8 | | - Эмнэлгийн тасаг, нэгж бүрт мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтыг баталгаажуулан, хэрэглээ, зарцуулалт, хадгалалт, хоосон тун шилийн устгалын бүртгэл тогтмол хөтлөх, хяналтын хуудсаар дотоод хяналт хийх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 32. | Өндөр эрсдэлтэй эм, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн хэрэглээнд тасаг, нэгжид хяналт хийдэг байх | 3.14 | | - Ижил нэртэй өөр тунтай эмийн нэршил, тун, савлагааг нарийвчлан шалгах, хяналтын хуудас хөтлөх, үнэлгээ дүгнэлт хийх. |
| Дэд бүлэг 7. МЭДЭЭГҮЙЖҮҮЛЭГ, МЭС ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| А.Мэдээгүйжүүлгийн тусламж, үйлчилгээ | | | | |
| 33. | Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх үйл ажиллагааны журамтай, мэдээгүйжүүлгийн аюулгүй ажиллагаа, орчинг бүрдүүлж ажилладаг байх. | 4.1 | Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийж журам батлаж, мөрддөг байх. | - Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн үед мэдээгүйжүүлэг хийх үйл ажиллагааны журамыг боловсруулан батласан байх,<br>- Хэрэгжилтэд хяналт тавьдаг<br>- Амулаторит мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх зөөврийн тоног төхөөрөмж болон эм эмнэлгийн хэрэгсэлээр хангадаг, аюулгүй ажиллагааг хангасан байх.<br>- Жил бүр үр дүнг тооцдог байх. |
| Дэд бүлэг 9. УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 34. | Уламжлалт анагаах ухааны тасаг, нэгжийг стандарт, шаардлагын дагуу зохион байгуулсан байх | 1.1 | Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 сарын 01-ны А/216 тоот тушаал “Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц батлах тухай”, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 6330:2017 стандартыг хэрэгжүүлэх; | - Уламжлалт анагаах ухааны оношилгоо эмчилгээг хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх 12 орыг Ковид-19 халдварын улмаас түр буулгасан байгааг дахин зохион байгуулж тусламж үйлчилгээг бүрэн үзүүлэх |
| 35. | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний зааврыг мөрддөг байх | 3.1 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/378 тоот “Монголын уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний заавар батлах тухай” тушаалыг хэрэгжүүлэх;<br>Монгол улсын стандарт MNS 5663-:2006 дагуу үзлэг оношилгоог бүрэн хийх; | - Тусламж, үйлчилгээний батлагдсан стандарт зааврыг мөрдөж эмчилгээ оношилгоо хийх;<br>- УАУ-ны оношилгоо хийхэд өвчний мөн чанар, гадар шинжийг уялдуулан дүгнэлтийг гаргаж оношийг тавих;<br>- Өвчний түүхийн бичилтэнд хяналт хийх, ялангуяа цахим өвчний түүхийн бөглөх хэсэг дутуу байгаад хяналт хийх; |
| 36. | Оношилгоо, эмчилгээ, ажилбар, үйлдэл хийх бүрт үйлчлүүлэгчийг зөв таних нөхцөлийг бүрдүүлсэн байх | 8.1 | Үзлэг, сувилгаа, гардан үйлдлийн өмнө үйлчлүүлэгчдийг зөв таних 2-оос доошгүй аргыг тусгасан үйлчлүүлэгчийг зөв таних журмыг боловсруулан сургалтыг бүх ажилчдад хийж, үйлчлүүлэгчдийг зөв | - Үйлчлүүлэгчдийг зөв таних журмыг ажилчдад сургаж сургалтыг жил бүр үйл ажиллагаа тогтворжтол хийх.<br>- Сургалтын чанарыг гардан үйлдлийн хяналтын хуудсаар үнэлж эмнэлгийн мэргэжилтэнд дадал суулгах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | таних аргыг өдөр тутмын дадал болгох | |
| 37. | Харилцааны бэрхшээлтэй өвчтөнийг таних аргыг нэвтрүүлсэн, мөрддөг байх | 8.2 | Хөгжлийн бэрхшээлтэй /харааны, сонсголын, хэл ярианы/ үйлчлүүлэгчээс мэдээлэл авах, мэдээлэл өгөх үйл явцыг дадал болгох | - Хөгжлийн бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчид үйлчлэх ажилтан бэлтгэх<br>- Сонсголын бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх дохионы хэлний ном, дэвтэр, харааны бэрхшээлтэй иргэдтэй харьцах ном зэргийг бэлтгэсэн байх<br>- Харилцааны аргыг хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчээр өөрөөр нь сонгуулдаг байх |
| 38. | Зөв өвчтөнд, зөв талбайд, зөв ажилбар хийх зарчмыг баримталдаг байх | 8.3 | Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/486 тоот тушаал Зүү эмчилгээний зааврыг мөрдөх;<br>Зонхилон тохиолдох өвчний зүү эмчилгээний удирдамж батлуулан мөрдөх; | - Зүү эмчилгээний жорыг өвчний түүхэнд тэмдэглэх;<br>- Зүү эмчилгээний картыг бүрэн хөтлөх;<br>- Зүү эмчилгээг гардан үйлдлийн хяналтын хуудсаар үнэлэх; |
| 39. | Ажилбар, үйлдэл хийх ажилбар бүрт хяналтын хуудас хөтөлдөг, үр дүнг тооцдог байх | 9.2 | Монгол улсын стандарт MNS4621:2008 дагуу гардан үйлдлийн хяналтын хуудасны тоог нэмэгдүүлэн хяналт үнэлгээний тоог нэмж эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах | - УАУ-ны тусламж үйлчилгээний үйлдэл бүрээр хяналтын хуудас боловсруулах;<br>- УАУ-ны тусламж үйлчилгээний стандарт удирдамжийн мөрдөлтөд хяналт тавих;<br>- Хяналтын үр дүнд үнэлгээ өгөн сургалт дадалжуулах ажлыг зохион байгуулдаг байх |
| Дэд бүлэг 10. ДОТРЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 40. | Тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ тогтмол хийж, сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх | 3.3 | "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" "MNS6330:2017" стандарт,<br>ЭМС-ын 2019 оны А/566 тушаалыг хэрэгжүүлэх | - Чанарын баг нь Тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтэд дүн шинжилгээ тогтмол хийж, сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх<br>- Эмнэл зүйн стандарт, удирдамжийн дагуу хяналтын хуудас боловсруулан батлуулж хуваарийн дагуу хяналт хийж үнэлэх |
| 41. | Жагсаалтаар баталсан өвчний оношилгоо, эмчилгээг стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг байх | 4.2 | "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа" "MNS6330:2017" стандарт,<br>ЭМС-ын 2019 оны А/566 тушаалыг хэрэгжүүлэх | - .Дотор судлалын чиглэлээр оношилгоо, эмчилгээ хийх өвчний жагсаалтыг баталсан байх<br>- Тусламж үйлчилгээ үзүүлэх стандарт аргачлал заавар журмаар ханган эмч мэргэжилтнүүдээ чадавхижуулах<br>- Тусламж үйлчилгээний технологийн мөрдөлтөнд хяналт үнэлгээ хийж дүгнэлт,судалгаатай ажиллах |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 42. | Үзлэг, оношилгоо, эмчилгээний ажилбар, үйлдэл хийхийн өмнө үйлчлүүлэгчийг таньдаг байх | 5.1 | “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа” “MNS6330:2017” стандарт, ЭМС-ын 2019 оны А/566 тушаалыг хэрэгжүүлэх | - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтын хүрээнд үйлчлүүлэгчийг зөв таних журам боловсруулж мөрдөж хэвших<br>- Оношилгоо, эмчилгээний ажилбар, үйлдэл бүрийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таних аргыг ашигладаг байх |
| Дэд бүлэг 19. НҮҮР АМНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 43. | Үзлэг, оношилгоо, эмчилгээнд хэрэглэх төхөөрөмжүүд нь хүрэлцэхүйц, бэлэн, эмчилгээний стандарттай нийцсэн байх | 7.1 | Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандартад заасан тоног төхөөрөмжийн хангалтын хувийг нэмэгдүүлэх | - Тасгийн засварын үйл ажиллагааг дуусган тоног төхөөрөмжийг шинэчлэх |
| Дэд бүлэг 22. СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ | | | | |
| 44. | Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх оношилгоо, үнэлгээний жагсаалтад заасан нэр төрлөөр оношилгоо, үнэлгээ хийдэг байх | 4.1 | Монгол улсын стандарт MNS4621:2008 дагуу гардан үйлдлийн хяналтын хуудасны тоог нэмэгдүүлэн хяналт үнэлгээний тоог нэмж эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах | - Сэргээн засах тусламж үйлчилгээний үйлдэл бүрээр хяналтын хуудас боловсруулах;<br>- Сэргээн засах тусламж үйлчилгээний стандарт удирдамжийн мөрдөлтөд хяналт тавих;<br>- Хяналтын үр дүнд үнэлгээ өгөн сургалт дадалжуулах ажлыг зохион байгуулдаг байх |
| 45. | Хэвтэн эмчлүүлсэн өвчтөний оношийн бүлгээр ангилан, дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгдөг байх | 4.5 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/502 тоот тушаалын 1-р хавсралтыг хэрэгжүүлэх | - Хэвтэн эмчлүүлсэн өвчтөний оношийн бүлгээр ангилан, дүгнэлт гарган эмчилгээний үр дүнг тооцдог байх |
| 46. | Ямар нэгэн ажилбар, үйлдэл хийхийн өмнө үйлчлүүлэгчийг таньдаг байх | 5.1 | Үзлэг, сувилгаа, гардан үйлдлийн өмнө үйлчлүүлэгчдийг зөв таних 2-оос доошгүй аргыг тусгасан үйлчлүүлэгчийг зөв таних журмыг боловсруулан сургалтыг бүх ажилчдад хийж, үйлчлүүлэгчдийг зөв таних аргыг өдөр тутмын дадал болгох | - Үйлчлүүлэгчдийг зөв таних журмыг ажилчдад сургаж сургалтыг жил бүр үйл ажиллагаа тогтворжтол хийх.<br>- Сургалтын чанарыг гардан үйлдлийн хяналтын хуудсаар үнэлж эмнэлгийн мэргэжилтэнд дадал суулгах |

Шинжээчдийн баг:

Ахлагч: Т.Наранзул

Гишүүд: Ж.Долгормаа
Д.Батцэцэг
Д.Баярмаа
Д.Батжаргал
Ч.Цэцэгмаа
Ж.Нямсүрэн
Д.Пүрэвдаш